



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/106

Дэлгэрхаан сум

**Газар эзэмших эрхийн гэрчилгээг
өвлүүлэн эзэмшүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, “Газрын тухай “ хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээг өвлөн авах хүсэлт гаргасан иргэн И.Долгорсүрэн (РД:СЛ53082301)-д түүний нөхөр Д.Бадарчийн эзэмшиж байсан 3 дугаар багийн нутаг Аварга тосонд байрлах 1976 м2/га кв.м газар эзэмших эрхийн гэрчилгээг 41 жилийн хугацаатай өвлүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмших гэрчилгээг шилжүүлэн авсан иргэнтэй гэрээ байгуулж, газар эзэмшилтэнд хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Ч.Батзориг)-т үүрэг болгосугай.

3.Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж, гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг (И.Долгорсүрэн)-д даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2006 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 48 дугаартай захирамжийн (Д.Бадарч)-д холбогдох хэсгийг хүчингүйд тооцсугай.

ДАРГА  Б.ЭНХ-АМГАЛАН

